

**АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС 2023 ОНЫ
08 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2023.09.04

Чойр

| № | Үүрэг даалгавар | Хэрэгжүүлэх хугацаа | Биелэлт | Хэрэгжилтийн хувь |
|---|--|---------------------|--|-------------------|
| 1 | Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, бэлтгэл ажлын явцыг танилцуулах | 2023.09.03 | <p>2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулахаар 21 арга хэмжээг төлөвлөн батлуулж 9-р сарын 05-ны өдрийн байдлаар 47.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу гоц халдварт шүлхийн эсрэг хаврын дархлаажуулалтад 18.6 мян.тол мал, амьтан хамруулахаас 409 өрхийн 17385 үхэр, 432 гахай нийт 17817 мал, амьтан хамруулж, гүйцэтгэл 96%-тай, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 519 өрхийн 297057 мал хамруулж гүйцэтгэл 98 хувьтай байна. Гоц халдварт цэцэг өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажил явагдаж байгаа ба 2023 оны 08-р сарын 28-ны өдрийн байдлаар 269 өрхийн 144898 хонь хамруулж гүйцэтгэл 53%-тай хийгдэж байна.</p> <p>ХХААГ Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу малчдын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн тооцоог гарган нийт 798 малчин өрхийг хонин толгойд шилжүүлснээр 715.1 мян.тол мал өвөлжих тооцоотой байгаа ба эдийн засгийн эргэлтэд 134.6 мян.тол мал буюу одоогийн байгаа малын 21.2 хувийг оруулах тооцоотой байна. Нийт малын 75 хувь нь дундаас дээш тарга хүчтэй байна. Малчдын түвшинд нийт малын 25 хувийг нэмэгдэл тэжээлээр тэжээхэд 10.2 мян.тн өвс, 1.7 мян.тн үйлдвэрийн тэжээл, 102 тн гар тэжээл, 644 тн хужир шүү шаардлагатай байна. Сүмбэр сумын 5 дугаар багийн 3 малчин өрх Төв аймгийн нутаг дэвсгэрээс 10 тн өвс бэлтгээд байна. 2023 онд нийт тариалсан талбай 68.48 га, үүнээс ургац алдсан талбай 1.083 га хураах талбай 67.4 га хүнсний ногооны 63% нь хамгаалагдсан хөрсөнд тариалсан ба урьдчилсан балансаар 167.2 тн төмс, 268.3 тн хүнсний ногоо, 1.83 тн жимс, жимсгэнэ хураан авахаар байна. Ургац хураалтад 41 дугуйт</p> | 50 |

| | | | | |
|-------------------------|--|------------|--|-------------|
| | | | трактор бэлэн, ажиллах хүч нэмэлтээр авах аж ахуйн нэгж байхгүй байна. | |
| 2. | Боржигин наадам болохтой холбогдуулан байгууллагууд гадна болон дотоод тохижилт засвар үйлчилгээнд анхаарах, ирэх оны төсөвт тусгах | 2023.09.03 | 2024 оны төсвийн төслийг 31 байгууллага ирүүлсэнээс гадна, дотор засвар үйлчилгээ, тохижилтын ажилд 500 сая төгрөгийг төсөвлөн төсвийн төсөлд тусгаад байна. | 100 |
| 3. | Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтэнд анхаарч ажлын явцыг эрчимжүүлэх. Мөн орон нутагт шилжин ирж байгаа иргэдийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтэс нэгтгэн танилцуулах | 2023.09.03 | 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар манай аймагт Улаанбаатар хотоос 118 иргэн, өөр аймгаас 224 нийт 342 иргэн шилжин ирсэн байна. | 30 |
| 4. | Цахилгаан гэмтэл, осол аваар гархаас урьдчилан сэргийлж салбарын байгууллагууд хамтран гудамж талбай, байр орон сууцны ил, далд утсыг цэгцлэх ажлыг эрчимжүүлэх | 2023.09.03 | Шивээговь суманд одоогийн байдлаар цахилгааны аюултай осол аваар гарахуйц гудамж талбай, байр орон сууцны ил, далд утас байхгүй бөгөөд иргэдийн аюулгүй байдал хангагдсан байна. Баянтал суманд гудамж талбайн ил цахилгааны утсын үзлэг шалгалт хийх, хамтран зохион байгуулах хүсэлтийг ОБГазар болон БЗӨЦТСүлжээ ХХК-ний Говьсүмбэр аймаг дахь салбарт албан хүсэлт хүргүүлсэн. Мөн урьдчилсан байдлаар сумын 154-р байрны хана дагуулж хийсэн 380 кв цахилгааны шугмыг далдлах аюулгүй байдлыг хангуулах, сумын 1-р багийн Дарга, БЗӨБЦТС-ний сум хариуцсан ажилтан нар хамтарч ажиллах төлөвлөгөө гаргасан. | 70 |
| Дундаж хэрэгжилт | | | | 62.5 |

Хянасан:

ХШҮ-ний хэлтсийн дарга:

М.АНХБАЯР

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:

ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн

Б.МӨНХЗАЯА

